



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 18 -ны өдөр

Дугаар A/49

Эрдэнэт

Г Дархлаажуулалтын бэлэн байдлыг хангаж,
хөрөнгө гаргах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дахь заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 13 дугаар зүйлийн 13.2 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 472 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний папиллома вирусын халдварын эсрэг вакциныг товллод нэвтрүүлэн бэлэн байдлыг хангах дэмжлэгт хяналтын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дархлаажуулалтын нэгжүүдийн бэлэн байдлыг ханган ажиллахыг Сум, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг товллод нэвтрүүлэх бэлэн байдлыг хангах ажлыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Дархлаажуулалт зоонозын халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн (П.Отгонбилэг)-д даалгасугай.
4. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 3,304,000(Гурван сая гурван зуун дөрвөн мянган төгрөг)-ийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (А.Ганчимэг)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
06 сарын 17-ны өдрийн
11/19 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХҮНИЙ ПАПИЛЛОМА ВИРУСЫН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ТОВЛОЛД НЭВТРҮҮЛЭН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ, ДЭМЖЛЭГТ ХЯНАЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго: Дархлаажуулалтын нэгжүүдийн хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг үндэсний товллолд нэвтрүүлэх бэлэн байдлыг үнэлж, цаашинд авах арга хэмжээг төлөвлөх

Хоёр. Үйл ажиллагааны чиглэл:

1. Дархлаажуулалтын нэгжүүдийн нэгжүүдийн хүний папиллома вирусын халдварын эсрэг вакциныг үндэсний товллолд нэвтрүүлэх бэлэн байдлыг хяналтын хуудсын дагуу үнэлж, анхаарах асуудлыг шийдвэрлэх
2. Эмч, эмнэлгийн ажилтануудад ажлын байранд сургалт зохион байгуулах
3. Дархлаажуулалтад хамрагдвал зохих хүүхдийн судалгааг ерөнхий боловсролын сургууль болон сум, багийн түвшинд нарийвчлан гаргах,
4. Иргэдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа хийж, үнэн зөв мэдээлэл хүргэх

Гурав. Хугацаа:

1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дархлаажуулалтын нэгжүүдэд дэмжлэгт хяналт хийх - 2024 оны 06 сарын 17- 27 –ны өдрүүд
2. Дархлаажуулалтын нэгжүүдэд хийсэн дэмжлэгт хяналтын дүн танилцуулах хурал зохион байгуулах - 2024 оны 07 сарын 05-ны өдөр
3. Баян-Өндөр сумын 24 баг Жаргалант сумын 3 багт ажиллаж, дархлаажуулалтад хамрагдвал зохих хүүхдийн судалгаа гаргах, иргэдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах - 2024 оны 07 сарын 15 – 27-ны өдрүүдэд
4. Ерөнхий боловсролын сургуулиудын дархлаажуулалт зохион байгуулах бэлэн байдлыг хангуулах – 09 сарын 03-13-ны өдрүүд

Дөрөв. Багийн бүрэлдэхүүн:

1. П. Отгонбилэг – Дархлаажуулалт, зоонозын халдварт өвчний тандалт сэргийлэл хариуцсан мэргэжилтэн
2. Б. Энхтүвшин – Дархлаажуулалтын бага эмч

Тав. Хамтран ажиллах байгууллага: Боловсрол шинжлэх ухааны газар, Бая-Өндөр сумын Засаг даргын тамгын газар, Жаргалант сумын Засаг даргын тамгын газар

Зургаа. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дотоодын сургалт, дэмжлэгт хяналт хийх хуваарь:

№	Дархлаажуулалтын нэгжийн нэр	Хяналт хийх хугацаа
1	Учралт баяр өрхийн эрүүл мэндийн төв	06 сарын 17
2	Энхжихмандирваа өрхийн эрүүл мэндийн төв	06 сарын 18
3	Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төв	06 сарын 19

4	Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв	06 сарын 20
5	Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төв	06 сарын 21
6	Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	06 сарын 24
7	Анхны оч өрхийн эрүүл мэндийн төв	06 сарын 25
8	Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төв	06 сарын 26
9	Жаргалант сумын эрүүл мэндийн төв	06 сарын 27

Долоо. Сум багийн түвшинд дархлаажуулалтад хамрагдвал зохих хүүхдийн судалгаа гаргах, иргэдэд чиглэсэн мэдээлэл хийх хуваарь

№	Багийн нэр	Хугацаа	Хамтран ажиллах эрүүл мэндийн төвийн нэр
1	Наран, Рашаант, Шанд	07 сарын 15	Үйлсбадрах, Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төв
2	Бүрэнбүст, Уртбулаг, Найрамдал	07 сарын 16	Анхны оч, Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төв
3	Цагаанчулуут, Баянбулаг, Булаг,	07 сарын 17	Нийцэл, Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв
4	Зэст, Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг	07 сарын 18	Анхны оч, Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төв
5	Говил, Баянцагаан,	07 сарын 19	Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төв
6	Даваат, Их залуу, Яргуйт, Баян-Овоот	07 сарын 22	Энхжихмандирваа, Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төв
7	Дэнж, Эрдэнэ, Чандмань, Чингэл	07 сарын 23	Учралтбаяр, Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв
8	Малчин	07 сарын 24	Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төв
9	Дулаан уул	07 сарын 25	Жаргалант сумын эрүүл мэндийн төв
10	Улаантолгой	07 сарын 26	Жаргалант сумын эрүүл мэндийн төв
11	Жаргалант	07 сарын 27	Жаргалант сумын эрүүл мэндийн төв

Найм. Ерөнхий боловсролын сургуулийн бэлэн байдлыг хангуулах дэмжлэгт хяналтын хуваарь

№	Сургуулийн нэр	Хугацаа	Хамтран ажиллах эрүүл мэндийн төв
1	1, 4, 5-р сургууль	09 сарын 03	Анхны оч өрхийн эрүүл мэндийн төв
2	2, 18-р сургууль	09 сарын 04	Мөнхсүндрэл өрхийн эрүүл

			мэндийн төв
3	13, 14, 19 -р сургууль	09 сарын 05	Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төв
4	3, 16, 17 -р сургууль	09 сарын 06	Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв
5	7, 15, 20, -р сургууль	09 сарын 09	Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төв
6	Ирээдүй одод, Орхон эмпати, 8-р сургууль	09 сарын 10	Энхжихмандирваа өрхийн эрүүл мэндийн төв
7	Жаргалант сумын ЕБС	09 сарын 11	Жаргалант сумын эрүүл мэндийн төв
8	Эрдмийн сан, Билэгт-Өргөө, Гэгээн билэг сургууль	09 сарын 12	Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв
9	Уран эгшиг, Маргад, Насан туршийн боловсрол	09 сарын 12	Мөнхийн гэгээ эрүүл мэндийн төв

Ес. Үр дүн:

1. Дархлаажуулалтын нэгжүүдийн хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг үндэсний товлонд нэвтрүүлэх бичил төлөвлөлтийг хийн, бэлэн байдлыг хангасан байна.
2. Эрүүл мэндийн ажилтнуудын шинэ вакцины болон бусад вакцины талаарх мэдлэг сэргэн чадавхина.
3. Дархлаажуулалтыг зохион байгуулахад салбарын дундын хамтын ажиллагаа сайжирч, иргэдэд үнэн зөв мэдээлэл хүргэсэн байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
06 сарын 18-ны өдрийн
А/149 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун/Дезель/	л	600	3800	2,280,000
2	Төмилөлт	Хүн	2*8 өдөр	64,000	1,024,000
Нийт дүн					3,004,000